

ГАМШИГТ ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН
ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ АСУУДАЛ

Ц.Ганчимэг ДХИС-ийн
Онцгой байдлын сургуулийн Гамшгаас хамгаалах
албаны тэнхимийн дэд профессор, дэд хурандаа,
доктор ts.ganchimeg77@gmail.com

Хураангуй

Уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтлын нөлөөгөөр дэлхийн ихэнх бүс нутаг, ялангуяа, Ази тивд байгалийн гамшгийн давтамж ихэсч, учруулж байгаа хор хөнөөл нь жилээс жилд нэмэгдсээр байна.

Дэлхийн хэмжээнд хүн, амьтан олноор нэрвэгдэж, эдийн засагт ихээхэн хохирол учруулсан 40 гаруй төрлийн гамшиг тохиолддог бөгөөд сүүлийн 10 жилд нийтдээ гамшгаас үүдэн 700 мянга гаруй хүн амь насаа алдаж, 1.4 сая гаруй хүн гэмтэж бэртэн, 23 орчим сая хүн олон гэргүй болж, 1.5 тэрбум гаруй хүн гамшигт ямар нэгэн байдлаар нэрвэгджээ. Үүнд эмэгтэйчүүд, хүүхэд, эмзэг бүлгийн иргэд харилцан адилгүй өртөж, нийт учруулсан хохирлын хэмжээ нь 1.3 их наяд ам.долларт хүрчээ⁶.

Сүүлийн жилүүдэд уур амьсгалын өөрчлөлт, хүн амын шилжилт хөдөлгөөн, ялангуяа, Улаанбаатар хотын экосистемийн бүс дэх хүн амын эрчимтэй өсөлт, хэт төвлөрлийн улмаас нийслэл хотод тохиолдох аюулт үзэгдэл, ослын давтамж, түүнд өртөх эмзэг байдал улам бүр нэмэгдэх хандлагатай байна. Иймд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гамшгийн эрсдэлийг бууруулах талаарх бүх шатны байгууллага, иргэд, олон нийтийн ойлголт, мэдлэгийг сайжруулах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, бэлэн байдлыг хангаж чадавхыг бэхжүүлэх зэрэг тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хэрэгцээ шаардлага байна.

Түлхүүр үг: Гамшгийн эрсдэл, эмзэг бүлэг, хууль, эрх зүй, сургалт дадлага

ABSTRACT: Due to climate change and environmental degradation, the frequency of natural disasters in most parts of the world, especially in Asia, has increased in recent years, and the impact of these impacts has increased with each passing year, especially in the region. The frequency of natural disasters on the continent has increased in recent years, and the damage they cause is increasing year by year.

There are more than 40 types of poverty in the world, from which people and animals have suffered a significant impact on the economy. In the last 10 years, more than 700,000 people have died, more than 1.4 million have been injured, and about 23 million have suffered. lost their homes and 1.5 billion were forced to leave their homes. More than a dozen people have suffered so or otherwise from natural disasters.

This includes: Women, children and vulnerable people suffered in various ways, the total damage amounted to 1.3 trillion dollars. In recent years, the frequency and vulnerability of natural disasters and accidents in the capital are increasing due to climate change and the impact, especially in the ecosystem of Ulaanbaatar. Therefore, it is necessary for our country to address such issues as the implementation of measures to reduce the risk of poverty, increase awareness and knowledge of organizations, citizens and the public at all levels of the reduction of risk of misconduct, poverty.

Keywords: Disaster risk, vulnerability, law, training and practice

Монгол Улсад гамшигт эмзэг бүлгийн эрсдэлийн өнөөгийн нөхцөл байдлыг үндэсний хэмжээнд тодорхойлох, бууруулах арга замыг хууль эрх зүй, тогтолцоо, засаглалын түвшинд авч үзэн, ялангуяа эмзэг бүлгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гамшгийн эрсдэлийг шинжилж, эрсдэлийг үнэлэх шаардлага тулгараад байгаа ч судалгаа харьцангуй бага байна.

Гамшигт эмзэг бүлгийн мөн чанарыг тодорхойлохын тулд системийн хандлагын өнцгөөс танин мэдэх арга зүй, логик холбоосон дээр тулгуурлан *нэгд*, гамшгийн мөн чанарыг шинжлэх; *хоёрт*, энэ ухагдахуун дээр тулгуурлан гамшгийн эрсдэлийг тодорхойлох; *гуравт*, дээрх хоёр ойлголтон дээр үндэслэн гамшгийн аюул болон аюулд өртөгдөх байдлыг тодорхойлох; *дөрөвт*, гамшгийн аюул болон аюулд өртөгдөх байдалд үндэслэн эмзэг байдлыг тогтоох; тавд, дээрх ойлголтуудын агуулгатай уялдуулан гамшигт эмзэг бүлгийн мөн чанарыг тодорхойлох зэргээр судалгааны логик холбоос, арга зүйн үндсийг бүрдүүлнэ⁷.

Гамшигт эмзэг бүлгийн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг дараах байдлаар авч үзвэл:

Хүн амын эмзэг бүлэг: Европын болон газар дундын тэнгисийн аюулын талаархи Байнгын ажиллагаатай хороо (EUR-OPA) 2011 онд эмзэг хүн амын гамшгийн эрсдэлийг бууруулахтай холбоотой ёс зүйн зарчмуудыг гаргасан байна. Энэхүү баримт бичиг нь Европ тивийн гамшгийн эрсдэлтэй холбоотой томоохон баримт бичигт тооцогдох бөгөөд ёс зүйн зарчмын гол зорилго нь эмзэг бүлгүүдийн гамшгийн эрсдэлийг бууруулах, гамшгаас урьдчилан сэргийлэх, эмзэг байдлыг бууруулах, бэлэн байдлыг хангах, даван туулах гэсэн ойлголтуудыг багтаасан бодлогын чанартай баримт бичгийг гаргахад тулгуурлах суурь баримт бичиг болдог байна.

Дээрхи баримт бичигт авч үзсэнээр эмзэг бүлэг гэж хөгжлийн бэрхшээлтэй иргэд, цагаачид, орогнол хүсэгчид, дүрвэгсэд, хүүхэд зэрэг нийгмийн дотор хамгийн эмзэгт тооцогдож байгаа бүлэг гамшиг тохиолдсон онц байдлын үед бие бялдарын болон сэтгэл санааны хямрал гэх зэрэг хэвийн бус байдал болон өөрсдийн эрхийг хамгаалуулах шаардлагатай хүмүүсийг нэрлэжээ.⁸

Түүнчлэн эмзэг бүлэг гэдэг нэр томъёонд нийгмийн дотор ямар нэгэн хүнд нөхцөл байдал үүссэн үед бусад хүмүүсийн адил өөрийгөө хянах чадвараа алддаг (ямар нэгэн хүчин зүйлийн нөлөөгөөр) хүүхэд, жирэмсэн эмэгтэй, өндөр настан, тэжээлийн дутагдалтай хүмүүс, хоригдол, цагаачид, дүрвэгчид, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлд донтогсод, ямар нэгэн өвчтэй хүн, дархлааны эмгэгтэй хүмүүсийг⁹ багтаасан байна.

Харин Агентлаг хоорондын Онц байдлын үеийн боловсролд зориулсан сүлжээ байгууллагын нэр томъёоны тайлбарт хүний анхан шатны хэрэгцээгээ хангаж чадахгүй онцгой тусламж шаардлагатай ямар нэгэн зөрчилдөөн эсвэл байгалийн гамшиг зэрэгт өртөх эрсдэлтэй, түүнийгээ даван туулах чадваргүй хүмүүсийг эмзэг бүлэг гэнэ¹⁰ гэж тодорхойлсон байна. Эдгээр бүлэг хүмүүсийн ядуурал эсвэл нийгмийн оролцооноос гадуур байдал зэрэг нь илүү их эрсдэлийг хүлээхэд нөлөөлдөг байна.

Гамшгийн эрсдэлийн удирдлагын эрх зүйн баримт бичгийн эмхтгэлд (2019) эмзэг бүлэг гэдэг нь тодорхой нөхцөл байдал, шалтгааны улмаас орон нутгийн хүн амаас гамшгийн аюулын нөлөөлөлд хамгийн түрүүнд өртөж, хохирол амсах магадлалтай бүлэг хүмүүс¹¹ гэж дурьджээ.

Тэгвэл манай улсын хувьд аливаа гамшигт дараах дөрвөн бүлэг хүмүүс эрсдэлд өртөх хамгийн их магадлалтай байна.

Үүнд:

- Хүйсний хувьд: эмэгтэйчүүд, ялангуяа жирэмсэн эхчүүд
- Насны хувьд: хүүхэд, ахмад настан
- Нийгмийн давхаргын хувьд: ядуу, ажилгүй хүмүүс, хүн амын амьжиргааны доод хэмжээнээс доогуур орлоготой гэр бүл¹²
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс

Өөрөөр хэлбэл, эмзэг бүлэгт хүүхэд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, аюулд өртөмтгий газар амьдарч байгаа хүмүүс, амьжиргаа нь зөвхөн нэг зүйлээс хамааралтай байдаг хүмүүс болон орон нутгийн ядуу иргэд хамаарч байна¹³.

Эмзэг бүлэгт нөлөөлөх гамшгийн эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлохын тулд: эхний ээлжинд дээрх ойлголтуудаас эмзэг бүлгийн талаарх хоёр ойлголтыг онцлон тэмдэглэх нь зүйтэй юм.

Үүнд: *нэгд*, эмзэг бүлэг гэдэг нь тодорхой нөхцөл байдал, шалтгааны улмаас орон нутгийн хүн амаас гамшгийн аюулын нөлөөлөлд хамгийн түрүүнд өртөж, хохирол амсах магадлалтай бүлэг хүмүүс *хоёрт*, ийм бүлэгт хүүхэд, хөгшид, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, аюулд өртөмтгий газар амьдарч байгаа хүмүүс, амьжиргаа нь зөвхөн нэг зүйлээс хамааралтай байдаг хүмүүс болон орон нутгийн ядуу иргэд хамаардаг болохыг зайлшгүй анхаарах шаардлага юм.

Энэ шаардлага нийт хүн амд тохиолдож байгаа аюулт үзэгдэл бүхэн эмзэг бүлэгт бусдаас илүү хүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйл болж байдгийг сануулж байгаа юм. Чингэхдээ үүний зэрэгцээ мөн түүнчлэн эмзэг байдал болон эмзэг бүлгийг үүсгэдэг шалтгааныг олж тогтоох нь чухал юм.

Эмзэг бүлэг нь дараах шалтгааны улмаас үүсдэг.

Хүснэгт 1. Эмзэг бүлгийг үүсгэх эрсдэлт хүчин зүйл


№	Шалтгаан	Үр дагавар
1	Уур амьсгалын өөрчлөлт (иргэдийн нөлөөлнө)	Бие мах бод, эрүүл сэтгэл санаа, амь нас, эдийн засаг хохирох
2	Гамшгийн аюулын давтамж нэмэгдэх	
3	Хүний буруутай үйл ажиллагаанаас байдал (хотжилт, технологийн хөгжил,)	
4	Иргэдийн гамшигт үзэгдэлд: -Бэлэн хангахгүй байх Гамшгийн лаван тунхах мэллэг чалвар байх	

Иймд “Эмзэг бүлэг” гэсэн ойлголтод гамшгийн үед илүү өртөх магадлалтай, өөрийгөө аюул ослоос хамгаалах чадваргүй хүн буюу өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд зэргийг хамааруулан тэднийг хамгаалахад тохирсон бодлого, төлөвлөлт хэрэгтэй болдог. Хамгийн ерөнхий утгаар нь гамшгийн эрсдэлийн аюул, эмзэг байдлын хоорондын харилцан үйлчлэлээс гарч болох хор уршиг, хохирлын магадлал байх зүй тогтлоор авч үзвэл дээрх хүчин зүйлсийн үр дагавар нь *нэгд*, оршин буй эмзэг байдал нь аюул бий болгох буюу үүнд илүүтэй өртөх нөхцлийг бий болгох, *хоёрт*, аюулд өртсөний дараа эмзэг байдалтай объект улам нэмэгдэх, мөн эмзэг бүлгийн тоо улам өсөх үйл явц үргэлжилж байгаагаар тайлбарлагдана.

Зураг 1.1 дээр эмзэг байдлын индекс¹⁴-ийг индексийн тодорхойлолт (4үзүүлэлт)-оор дамжуулан индексийн хувьсагч (индексийн тодорхойлолтын үзүүлэлт тус бүрд

харгалзсан 2–4 үзүүлэлт) болон тэдгээрт харгалзуулан Монголын нийгмийн эмзэг байдлын хувьсагчийн тодорхойлолтыг үзүүлсэн бөгөөд энэ нь цаашдын эмзэг байдлын шинжилгээ болон зөвлөмж боловсруулахад эдгээрийг харгалзан үзэх боломжийг бүрдүүлж байгаа болно.

Зураг 2. Эмзэг байдлын индекс



Эх сурвалж: Social Vulnerability Index themes and social factors

Гамшигт, осолд хамгийн түрүүнд нийгмийн эмзэг бүлэг ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өртөх магадлал өндөр байдаг нь гадаад орны судалгаанаас харагддаг бөгөөд Австрали, Япон, Филиппин, АНУ зэрэг улс орнууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн гамшгийн үеийн бэлэн байдал, нүүлгэн шилжүүлэлтийн талаар судалгааны ажлуудыг өргөн хүрээнд хийсэн байдаг.

Харин манай оронд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн гамшгийн эрсдэлийг шинжилж, эрсдэлийг үнэлсэн судалгаа хомс байгаа тул энэхүү асуудлыг зайлшгүй судлах шаардлага тулгарч байна.

ГАМШИГТ ЭМЗЭГ БҮЛГИЙН ИРГЭДИЙН ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ТОДОРХОЙЛОХ СУДАЛГАА:

Энэхүү чанарын судалгааг нийгмийн эмзэг бүлэгтэй ажилладаг эксперт болж чадах бүлэг буюу төрийн болон төрийн бус байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдээс дараах зорилтын хүрээнд судалгааг авч шинжлэв. Үүнд:

1. Нийгмийн эмзэг бүлэгт чиглэсэн гамшгаас хамгаалах сургалт, дадлага түүний үр дүн
2. Гамшгаас хамгаалах олон нийтийн сургалтад нийгмийн эмзэг бүлгийн хамрагдах боломж ямар байгааг тодорхойлох
3. Нийгмийн эмзэг бүлэгт гамшгаас хамгаалах ямар сургалт, арга хэмжээ хэрэгцээтэй байгааг тодорхойлох

4. Нийгмийн эмзэг бүлэгт төрийн байгууллагаас шаардагдаж буй арга хэмжээ
5. Эрх зүйн зохицуулалтын өнөөгийн байдал, хэрэгжилт

Судалгааны түүврийн дизайны үе шатыг мэдээлэл цуглуулалтын зардлын хамгийн бага түвшинд байх, төлөөлөх чадварын үзүүлэлтүүд (түүврийн алдаа)-ийг хүлээн зөвшөөрөгдөхүйц байх зарчмыг баримтлан нийслэл хот, дүүрэгт 1 үе шаттайгаар төлөвлөж хэрэгжүүлсэн.


СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Энэхүү судалгаанд 19–49 насны 157 Онцгой байдлын газар, хэлтсийн албан хаагчийг хамруулсан. Судалгаанд оролцогчдын дундаж нас 29.9±6.7, 83.8 хувийг эрэгтэйчүүд эзэлж байв. Нийт оролцогчдын ажилласан жил 1 – 3, дундааж 1.78±0.81 байв.

Хүснэгт 1. Судалгаанд оролцогсодын хүн ам зүйн үзүүлэлт


Үзүүлэлт	Тоо	Хувь
Харьяалал		
Хөдөө	60	40.5
Хот	88	59.5
Хүйс		
Эрэгтэй	124	83.8
Эмэгтэй	24	16.2
Боловсрол		
Баклавр	92	62.2
Диплом	44	29.7
Магистр ба Доктор	12	8.1
Нас (дундаж, сx)	29.92	6.72
Ажилласан жил (дундаж, сx)	1.78	0.81
Нийт	157	100.0

Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах хууль эрх зүйн орчны өнөөгийн байдалд судалгаанд оролцогчдын 23.9% муу, 59.2% дунд гэж үнэлгээ өгчээ. Хууль эрх зүйн орчны өнөөгийн байдалд өгч буй оролцогчдын үнэлгээ нь хот, хөдөө ба боловсролын түвшингээр статистик ач холбогдол бүхий ялгаагүй байв ($p = 0.12$, $p =$



0.026).


Зураг 1. Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах хууль, эрхзүйн орчны өнөөгийн байдал



Гамшгийн

эрсдэлийг бууруулахад нийгэм, соёлын тулгарч буй асуудал:

Судалгаанд оролцогчдын 24.3% агаарын бохирдол, 23.0 % ажилгүйдэл, 14.9% аюул осол, эрсдэл 14.2% хэт төлөвлөрөл, хотжилтыг гамшгийн эрсдэлийг бууруулахад тулгамдаж буй асуудал болохыг тодотгожээ. Түүнчлэн нийт оролцогчдын 4.1% нь боловсролын ялгаа, эрүүл мэндийн үйлчилгээ, уур амьсгалын өөрчлөлтийг гамшгийн эрсдэлийг бууруулахад тулгамдаж буй асуудал гэж үзсэн байна.



Зураг 3. Эмзэг бүлгийг гамшгаас хамгаалахад талуудын оролцооны түвшин

Нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамгаалахад талуудын оролцоо: Нийт судалгаанд оролцогчдын 11.8 хувь удирдлагын оролцоо, 21.5 хувь ААН оролцоо, 21.6 хувь иргэдийн оролцоог нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг хамгаалахад талуудын оролцоо хангалтгүй буюу муу гэж дүгнэжээ.

Эмзэг бүлгийн иргэдийг хамгаалахад удирдлагын оролцоо 59.7 хувьд дундаас бага түвшинд байв. ААН-ын оролцооны түвшин 72.2 хувьд дундаас бага байжээ. Түүнчлэн иргэдийн оролцооны түвшин 73.6 хувьд дундаас бага түвшинд бага байгаа нь ААН ба удирдлагын оролцооноос харьцангуй доогуур үзүүлэлт болж байна.

Аврах ангийн мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөцийн хүрэлцээ: Аврах ангийн мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөцийн хүрэлцээний түвшинг 14.4 хувь хангалтгүй, 56.8 хувь дунд, 24.2 хувьд сайн, 4.8 хувь нь маш сайн гэж үнэлсэн ба хот, хөдөө орон нутагт хүний нөөцийн хүрэлцээний түвшин статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна

($p = 0.716$).

Аврах ангийн техник, багаж хэрэгслийн хүрэлцээ, бэлэн байдлыг нийт оролцогчдын 14.4 хувь муу, 56.8 хувь дунд гэж үнэлжээ. Хөдөө орон нутагт техник багаж хэрэгслийн хүрэлцээг оролцогчдын 6.8 хувь муу гэж үнэлсэн боловч нийслэлийн хувьд статистик үнэн магадтай ялгаа ажиглагдаагүй байна($p = 0.162$).

Нийслэлийн Аврах ангийн бүрэлдэхүүн гамшгийн үед эмзэг бүлгийн иргэд, ХБИ-дэд үзүүлэх тусламжид шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хүрэлцээ бэлэн байдлыг оролцогчдын 71.2 хувь дундаас түвшинд үнэлгээ өгчээ.

Хүснэгт 2. Эмзэг бүлгийн иргэдийг гамшгаас хамгаалах хүний нөөц ба аврах ангийн бэлэн байдал

Үзүүлэлт	Нийт		Харьяалал				Р утга
			Хөдөө		Хот		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Аврах ангийн мэргэжлийн боловсон хүчин, хүний нөөцийн хүрэлцээний түвшин							0.716
Муу	21	14.4	10	16.9	11	12.6	
Дунд	83	56.8	32	54.2	51	58.6	
Сайн	35	24.0	15	25.4	20	23.0	
Маш сайн	7	4.8	2	3.4	5	5.7	
Аврах ангийн техник, багаж хэрэгслийн хүрэлцээ, бэлэн байдал							0.162
Муу	13	8.9	4	6.8	9	10.3	
Дунд	75	51.4	29	49.2	46	52.9	
Сайн	44	30.1	19	32.2	25	28.7	
Маш сайн	14	9.6	7	11.9	7	8.0	

Эмзэг бүлгийн иргэдийг гамшгаас хамгаалах, аврах сургалтад албан хаагчдын 2.1 хувь огт хамрагдаж байгаагүй, 19.7 хувь 1 удаа хамрагдсан, 78.9 хувь 2 ба түүнээс дээш хамрагдсан байв. Сургалтад 2 ба түүнээс дээш хамрагдсан байдал Улаанбаатар хотод 72.9 хувь байгаа нь хөдөө орон нутгаас харьцангуй бага үзүүлэлт болж байна.

Эмзэг бүлгийн иргэдийг гамшгийн үед хамгаалах дадлагад оролцогчдын 2.9 хувь огт хамрагдаж байгаагүй, 20.3 хувь 1 удаа хамрагдсан байв. Дадлага сургалтад хамрагдсан байдал хөдөө хотод статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна.


($p = 0.456$)

Мөн оролцогчдын гамшигаас хамгаалах бусад арга хэмжээнд хамрагдсан байдал 21.8 хувь 1 удаа хамрагдсан, 77.4 хувь 2-оос дээш давтамжтай оролцсон байна.

Хүснэгт 3. Эмзэг бүлгийн иргэдийг гамшгаас хамгаалахад бэлтгэх сургалт дадлага

Үзүүлэлт	Нийт		Харьялал				Р утга
			Хөдөө		Хот		
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	
Сургалт							0.265
1 удаа	28	19.7	8	14.0	20	23.5	
2< удаа	111	78.2	49	86.0	62	72.9	
Огт үгүй	3	2.1	0	0.0	3	3.5	
Дадлага							0.365
1 удаа	28	20.3	11	19.6	17	20.7	
2< удаа	106	76.8	44	78.6	62	75.6	
Огт үгүй	4	2.9	1	1.8	3	3.7	
Бусад арга хэмжээг							0.456
1 удаа	29	21.8	13	24.1	16	20.3	
2< удаа	103	77.4	41	75.9	62	78.5	
Огт үгүй	1	0.8	0	0.0	1	1.3	



Эмзэг бүлгийн иргэдэд гамшгаас урьдчлан сэргийлэх мэдээлэл хүргэх арга хэрэгсэл ба хүртээмж: Нийт судалгаанд оролцогчдын 11.7 хувь эмзэг бүлгийн иргэдэд гамшгаас урьдчлан сэргийлэх мэдээлэл хүргэх түвшинг муу гэж дүгнэсэн ба 60.7 хувь дунд гэж үзжээ. Түүнчлэн эмзэг бүлгийн иргэдэд мэдээлэл хүргэх тохиромжтой мэдээллийн эх сурвалжийг 52.7 хувь телевиз, 32.9 хувь гар утас гэж үзсэн байна.



Зураг 4. Эмзэг бүлгийн иргэдийн гамшгаас хамгаалах мэдээллийн хүртээмж, арга хэрэгсэл

Судалгаанд оролцогчдын 58.3 хувь гамшиг, ослоос аврах ажиллагааны үед ашиглах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж огт байдаггүй, 3.6 хувь шаардлагагүй гэж үзжээ. Хөдөө орон нутаг ба хотод хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан гамшиг, ослоос аврах тусгай хэрэгсэл тоног төхөөрөмжийн хүртээм ач холбогдол бүхий ялгаагүй бага түвшинд байна.

Зураг 5. Гамшиг, ослоос аврах ажиллагааны үед ашиглах хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж



Нийт судалгаанд оролцогчдын 53.1 хувьд гамшиг, аюулт үзэгдэл, ослын үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн аврах ажиллагаа гарч байгаагүй гэж мэдээлжээ. Мөн оролцогчдын 25.0 хувь маш их, 19.5 их хэмжээний хүндрэл бэрхшээл гардаг гэж үзсэн байна.

Зураг 6. Гамшиг, аюулт үзэгдэл, ослын үеэр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг аврах ажиллагаанд гардаг хүндрэл бэрхшээл

Онцгой байдлын алба хаагчдын 40.1 хувь нь эмзэг бүлгийн иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах үр дүнтэй үйл ажиллагаа нь сургалт дадлага гэж үзсэн бол 15.6

хувь эрх зүйн орчинг сайжруулах гэж үзжээ.

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаанаас шалтгаалсан асуудал нийт оролцогчдын 29.9 хувьд маш их тохиолддог байна.

Хүснэгт 5. Эмзэг бүлгийн иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах үр дүнтэй үйл ажиллагаа ба салбар хоорондын уялдаа холбоо

Үзүүлэлт	Харьяалал		Хот		Нийт	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
Эмзэг бүлгийн иргэдийн гамшгийн эрсдэлийг бууруулах үр дүнтэй үйл ажиллагаа						
Сургалт, дадлага	29	48.3	30	34.5	59	40.1
Эрх зүйн орчныг сайжруулах	6	10.0	17	19.5	23	15.6
Иргэдийн хандлагыг өөрчлөх	18	30.0	22	25.3	40	27.2
Нийгмийн халамжийг сайжруулах	2	3.3	12	13.8	14	9.5
ОББ эрсдэлийг бууруулах арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх	5	8.3	6	6.9	11	7.5
Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд салбар дундын уялдаа холбоо, хамтын ажиллагаанаас шалтгаалсан асуудал						
Огт байхгүй	6	13.3	6	9.4	12	10.3
Тохиолдож	9	20.0	18	28.1	28	23.9

байгаагүй						
Маш их	16	35.6	16	25.0	35	29.9
Маш бага	14	31.1	24	37.5	42	35.9

ДҮГНЭЛТ

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр гамшгийн давтамж, эрчим нэмэгдэж, тогтвортой хөгжилд саад учруулж, бүх л улс орны ард иргэдэд хөрөнгийн гамшигт өртөх байдал нь эмзэг байдал буурахаас илүү хурдтай нэмэгдэж, гамшгийн шинэ эрсдэлийг бий болгохоос гадна нийгэм эдийн засаг, эрүүл мэнд, соёл, хүрээлэн буй орчинд богино, дунд, урт хугацаанд ноцтой нөлөөлөн ялангуяа орон нутаг, олон нийтийн түвшинд гамшгийн хохирол улам бүр нэмэгдэж байна.

Иймд гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд бүх нийтийн оролцоог хангасан түншлэл, хамтын ажиллагааг хөгжүүлж, гамшигт харилцан адилгүй өртсөн иргэд, ялангуяа ядуу иргэдэд онцгой анхаарал хандуулан сургалт дадлагааар мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаанд хүртээмжтэй оролцуулах хэрэгтэй байна.

Мөн гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаа, менежмент нь салбарын болон салбар хоорондын, холбогдох байгууллагууд хоорондын үйл ажиллагааг бүх түвшинд уялдуулан зохицуулж, хууль тогтоох болон төрийн гүйцэтгэх бүх байгууллагуудын оролцоог хангах нь чухал юм.

Ашигласан хэвлэл

1. Гамшгаас хамгаалах тухай хууль
2. Ц.Ганчимэг. Гамшигт эмзэг бүлгийн эрсдэлийг бууруулах боломж., Доктор (Ph.D)-ын диссертаци. УБ. ДХИС. 2021.
3. www.Coe.int/en/web/europarisks/vulnerable-groups.
4. www.inee.org/eie-glossary/vulnerable-groups.
5. www.pallipedia.org/vulnarible-groups/
6. Planning for an Emergency: Strategies for Identifying and Engaging At-Risk Groups., Atlanta (GA): CDC; 2015.
7. Гамшгийн эрсдэлийн удирдлагын эрх зүйн баримт бичгийн эмхтгэл. УБ., 2019. 131 дэх тал.
8. Монгол Улсын “Хүн амын амьжиргааны доод түвшинг тодорхойлох тухай” хууль. УБ., 1998. Төрийн мэдээлэл №12
9. Гамшгийн эрсдэлийг бууруулах чиглэлээр 2015-2030 онд хэрэгжүүлэх Сендайн үйл ажиллагааны хүрээ. УБ., 2016